



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 07

Чойр

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 235,282,445.93 (хоёр зуун гучин таван сая хоёр зуун наян хоёр мянга дөрвөн зуун дөчин таван төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 1 нэр төрлийн хөрөнгийг хавсралтад заагдсаны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газарт балансаас балансад шилжүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч (Б.Анхбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор зохион байгуулах;

2.2. Эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ” маягтын дагуу гаргаж хуулийн хугацаанд Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 04 дүгээр улиралд багтаан ирүүлэх;


3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ



Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 11
 дүгээр хуралдааны 11 дугаар тогтоолын хавсралт



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН 2-Р СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ХӨРӨНГИЙГ
 БОЛОВСРОЛ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Шилжүүлж авах байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Марк, төрөл	Хөрөнгийн ангилал	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Боловсрол соёл шинжлэх ухааны газар	2-р сургуулийн спорт заал	тоосгон	Барилга байгууламжийн орон сууц	12/31/2018	ш	1	235,282,445,93	235,282,445,93	22,221,119,90	22,221,119,90
	НИЙТ ДҮН							235,282,445,93	235,282,445,93	22,221,119,90	22,221,119,90